



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/Б-98

Алтай хот

**Малын шилжилт хөдөлгөөнийг
хязгаарлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12, 7.12.1, 7.12.2, 7.12.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт шүлхий, үхрийн арьс товруутах, бог малын мялзан, хонины цэцэг өвчний гаралт тархалт нэмэгдэж зарим аймагт хорио цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжиж байгаатай холбогдуулан өвчин зөөвөрлөгдөн тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймаг сумаас өөрийн аймгийн нутагт ирэх зөвшөөрөлгүй отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнийг 2022 оны 9 дүгээр сарын 22-ноос 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хориглосугай.

2.Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, эрт илрүүлэг, үзлэг тандалт, халдваргүйтгэлийг эрчимжүүлж, гоц халдварт, халдварт өвчний талаарх мэдээлэл, сэрэмжлүүлгийг малчид, иргэдэд хүргэх, аймаг доторх малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийн малд мал эмнэлгийн гэрчилгээ олгон, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, мал эмнэлгийн улсын байцаагч мөн аймгаас хүлээж авах махны үйлдвэрийн хаяг тодорхой, хүнсний зориулалттай амьд малд тээвэрлэлтийн үеийн мал эмнэлгийн гэрчилгээ олгон хүнсний хангамжид хүндрэл үүсгэхгүйгээр зохицуулж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001965